

ҮНЭЭНИЙ ГИМНАСТИК

Үнээнүүд өөрсдийнхөө бие бялдрыг хөгжүүлэх гээд гимнастикаар хичээллэхээр болжээ! Фэрмэр Болд өөрийнхөө хайртай үнээ болох Бэссиг бусад N үнээг дасгалжуулан гимнастик сурах явцад гарч буй ахицыг үнэлүүлэхээр болжээ.

K бэлтгэл болгоны ($1 \leq K \leq 10$) хувьд Бэсси N үнээг ($1 \leq N \leq 20$) тэдний үр дүнгээр нь эрэмбэлэн жагсаан гаргасан ажээ. Үүний дараа тэрбээр жагсаалтын тогтвортой байдлыг сонирхохоор шийджээ. Ялгаатай хоёр үнээг хэрэв аль нэг нь нөгөөгөөсөө бэлтгэл болгонд илүү үзүүлэлт гаргасан бол тэднийг *тогтвортой* хос гэнэ.

Тэгвэл Бэссид нийтдээ хичнээн тогтвортой хос байгааг тоолж өгнө үү.

Input

Эхний мөрөнд хоёр эерэг бүхэл K болон N тоонууд байрлана. Дараагийн K мөр болгонд $1 \dots N$ хүртэлх тоонууд ямар нэгэн сэлгэлттэй байрлах бөгөөд үнээнүүдийн эрэмбийг илэрхийлэх юм. (үнээнүүд $1 \dots N$ хүртэлх тоогоор илэрхийлэгдсэн байгаа). Хэрэв аль нэг мөрний хувьд A нь B -н өмнө орсон байвал A үнээ B үнээнээс сайн байсан гэсэн үг юм.

Output

Нэг мөрөнд тогтвортой хосуудын тоог хэвлэнэ үү.

Example

Input:

```
3 4
4 1 2 3
4 1 3 2
4 2 1 3
```

Output:

```
4
```

Тайлбар :

Тогтвортой хос үнээнүүд нь (1,4), (2,4), (3,4), (1,3) болно.

Зохиогч: Nick Wu

Орчуулсан: Battulga Enkhbayar